



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/62

Улаанбаатар хот

Хяналт шалгалт хийх Ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж болох "Содхан" ХХК-ийн гэрээг дүгнэх, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж, удирдамжийг хавсралтаар баталсугай.

Ахлагч:

Дүүргийн менежер

Гишүүд:

Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга
Дүүргийн Дотоод аудитын албаны дарга
Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга

Нарийн бичгийн
дарга:

Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

2. Батлагдсан удирдамжийн дагуу хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж, 2025 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн дотор үр дүнг танилцуулан ажиллахыг Ажлын хэсэг (Н.Сугар)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (З.Бямбажав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1525010209

Чингэлтэй дүүргийн Засаг даргын
2025 оны 02 дугаар сарын 19 өдрийн
11/62 дугаар захирамжийн хавсралт

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг. Шалгалтын зорилго, үндэслэл:

1.1. Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангуулах, баталгаажуулах, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах, худалдааны чөлөөт байдлыг хадгалахад оршино.

Хоёр. Хамрах хүрээ, хугацаа:

2.1. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж "Содхан" ХХК нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандарт, дотоод хяналтын чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй эсэх, гэрээний үүргийн биелэлтийг ханган ажиллаж буй эсэх талаар хяналт шалгалт хийх бөгөөд хяналт шалгалтыг 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн 2025 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн дотор багтаан хийж гүйцэтгэнэ.

Гурав. Хяналт шалгалтын төрөл, хэлбэр:

3.1. Төлөвлөгөөт бус хяналт шалгалт

Дөрөв. Шалгалтын арга:

4.1. Хяналт шалгалтын ажлын хэсэг нь аж ахуй нэгж байгууллагын баримт бичиг, мэдээлэлтэй танилцах, хянан үзэх, тайлбар авах, ажлын байранд үзлэг хийх, илэрсэн зөрчил дутагдлыг баримтжуулан фото зураг авах, дүрс бичлэг хийх, баримт бичгийг хуулбарлан баталгаажуулах, шаардлагатай тохиолдолд ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд хэмжилт, шинжилгээ хийх болон хуульд заасан бусад аргаар хяналт, шинжилгээ, шалгалтыг хийж гүйцэтгэнэ.

4.2. Шалгалтыг хэрэгжүүлэх явцдаа шалгуулагч этгээдийн эрсдэлийн ангиллыг танилцуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах талаар тухайн шалгуулагч этгээдийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг таниулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч зөвлөн туслах ажлыг хэрэгжүүлнэ.

Тав. Хяналт шалгалтын дүнг тайлагнах:

5.1. Хяналт шалгалтын ажлын хэсэг удирдамжид заасан хугацаанд хяналт шалгалтыг хийж, дүнг шалгуулагч этгээд болон удирдах албан тушаалтанд танилцуулна.

5.2. Төлөвлөгөөт бус хяналт шалгалтын дүн, нэгдсэн мэдээ, танилцуулгыг удирдлагад танилцуулж, зохих шийдвэрийг гаргуулан, цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулна.